

СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

**УЛСЫН НОМЫН САНГИЙН УУГАН ФОНД
(УННС-ийн 60 жилийн ойд)****Н. Дашзэвэг**

БНМАУ-ын нийтийн номын сан (УННС) бол ардын хувьсгалын ялалтаар бий болсон манай соёлын томоохон төв юм. 1921 оны арван нэгдүгээр сард Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд төвд ном голлосон 2000-аад номтой үүссэн анхны номын санг 1924 онд УННС болгон өргөтгөжээ. Тэр үед жилд 120 орчим уншигчдад үйлчилж байсан бол одоо өдөрт 200-300 хүн, жилд 100 мянган хүнд үйлчилж байна.

Тус номын сан монгол, төвд, санскрид, манж, хятад, орос, англи зэрэг 10 гаруй хэлний 3 сая гаруй номтой. УННС-г хөгжүүлэх үйлсэд О. Жамъян (Д. Сүхбаатарын багш), Ч. Бат-Очир, Дашням, Цэвээн-жамсранов, Амар нарын олон хүний хувь нэмэр оролцсоны зэрэгцээ ЗХУ-ын мэргэжилтэн М. И. Кондратьева, Н. П. Шастина, сүүлийн жилүүдэд Н. Ф. Фридгут, К. Н. Михайлов, В. М. Владимиров, А. В. Наумова, А. М. Кайгородов нарын санаачлага үнэт зөвлөлгөө ихээхэн үүрэг гүйцэтгэснийг хэлэх хэрэгтэй.

УННС 1930 оноос эхлэн ЗХУ-ын В. И. Лениний нэрэмжит улсын нийтийн номын сантай тогтмол харилцаатай ажиллаж, түүний баялаг туршлагаас байнга суралцаж байна.

Тус номын сан Европ, Монгол, Төвд, Дорно дахины сонин сэтгүүл, бэлтгэл архивзэрэг 6 фондтой бөгөөд үүнээс томоохон ууган фонд нь Төвд номын фонд юм. Уг фондод Энэтхэг, Төвд зэрэг улс оронд нэгэнт олдохоо байсан ховор нандин гар бичмэл байхын зэрэгцээ мөнгөн хуудсанд алтаар бичсэн ном, есөн эрдэнээр бичсэн ном зэрэг нэг сая судар, шастир нандигнан хадгалагдаж байна.

Манай эрдэмтдийн судалгааны чухал хэрэглэгдэхүүн болсон эртний Энэтхэг-төвдийн арван ухааныг хамарсан Ганжуур, Данжуур болон 1671 онд Төвдөөс өндөр Гэгээн Занабазарт бэлгэлсэн 110 боть гар бичмэл Ганжуур, 1907 онд Их хүрээнд зэс бараар барласан «Хүрээ ганжуур» 103 боть, 1927 онд Хөх хотоос О. Жамъян олж авчирсан Монгол үсгийн шунхан ганжуурын 108 боть, данжуурын 220 боть бүрэн эхээр байна, Эртний Энэтхэгийн алдарт эрдэмтэн Нагаржунайн дал модны навчин дээр бичсэн гэдэг «Найман мянган шүлэгт»- (Жадамба) судараас эхлэн 1910 онд Мандширийн хийдэд Дагва тэргүүтэй хэсэг дархчууд цалин цагаан мөнгийг цаасан хуудас шиг болгон давтаж, түүн дээрээ үсэг товойлгон алтаар шарж урласан Буддагийн гүн ухааны онол «Нууц хураангуйн үндэс» (Сандуйн-жүд), «Очироор огтлогч»-(Дорж-жодов) зэрэг ном хэвлэлийн хувьд хосгүй гайхамшигт бүтээл бас багтдаг.

XX зууны эхээр Бор Чултэм, Доржбал зэрэг олон дархчууд хамтран маш урлагтай сийлсэн «Жадамба» судрын зэс бар, «Мэргэд гарахын орон» хэмээх толь бичгийн модон бар, мөн алт мөнгө тэргүүтэн есөн эрдэнээр мөр алаглуулан бичсэн Ганжуурын бүрэн боть тус тус байдаг. Үүнээс гадна тус фондод Энэтхэгийн гүн ухаантан Будда, Төвдийн их

эрдэмтэн Сумаадий Киртий, ертөнцийн үзэсгэлэнт зургаан чимэг гэж алдаршсан Нагаржунай, Васиу Ванду, Асанга, Дармаа Киртий бас «хоёр дээд» гэж алдаршсан Шагжаа-Од, Ёндон-Од нарын гүн ухаантан, эрдэмтдийн бичсэн «Сүмбум» иж бүрэн эмхтгэл зохиолууд байна. Бүрэн бус мэдээгээр Монгол ном, зохиол бичсэн 200 гаруй лам нарын зохиол байдаг. Заримаас нь дурдвал: «Сольболцон барих бодорол» гэдэг одон-зурхайн зохиол, Халхын Зая Бандида Лувсанпэрэнлэйн «Са-ег» хэмээх түүхийн холбогдолтой ном, Баруун Монголын Зая Бандида Намхайжалцаны тод үсгийн зохиол, гүн ухаантан гавж Агваанхайдав, Агваанбалдан, Шижээравсал, бичээч цорж Агваанцэрэн, хэлний шинжээч Агваан-Иштүвдэн Ранжамба, яруу найрагч Ноён хутагт Данзанравжаа, их бага арван ухааны сонин зохиол бичсэн Агримба Шаравдандар (Булган аймаг), Даш-доогү гүний Данзан-Чомзод (Баянхонгор аймаг), анагаах ухааны дөрвөн үндэс болон, хүн эмнэлгийн олон сонин зохиол бичсэн ламын гэгээн Данзанжалцан (Өвөрхангай аймаг), таван хошуу малын эмнэлгийн ном бичсэн тарган бандида Цэвэл Ванчигдорж (Өвөрхангай аймаг), дээд монголын их эрдэмтэн Нээж тойн Авид, их тоочин Мянгат, яруу найрагч Инжинааш, Өвөр Монголын Сүмбэ Хамба Ишбалжир, цахар гэвш Лувсанчүлтэм, Гүн зуугийн гэгээн Ишданзан Ванжил, халхын их түүхч Заваа Хамба гавж Ш. Дамдингийн зохиол «Монголын их түүх» (Хорчойнжүн) мөн Гүн Гомбожавын «Хар хятадын түүх» (Жанаг Чойнжүн) Цэмбэл гүүш, Дарамдалай нарын «Их Монголын түүх» (Хорчойнжүн) зэрэг сонин номуудаас гадна төвдийн алдарт оточ Юутог-Ёндонгомбын зохиол «Анагаах ухааны дөрвөн үндэс» (Жүд-Ши), Дэсэрд Санжаажамцын «Нэмэлт эмнэлэг» (Лхантав), Дараммаарамба Лувсан-чойдогийн «Битүүмчит нууц увидасын эмнэлэг» (Ман-Аг-гар-жам) гэхчилэн анагаах ухааны маш олон ном байна.

Хэл шинжээч эрдэмтэн Алшаа нутгийн Лхарамба Авгаандандар нарын зэрэг мэргэдийн «Иж бүрэн эмхтгэл» (Сүмбум) зохиолуудаас гадна Нанхиадын эртний жуулчин лам Тан-саны зохиол «Хаш хайрцаг» буюу (Ян дий самдог) хэмээх одон зурхайн ном, Мэндэл номун хаан Жамбал чойжи Данзан пэрэнлэйгийн бичсэн «Ази тивийн байдлын тухай дэлгэрэнгүй номнол» (Замилин жай шад), мөн Буриадын лам Дооромбо Гэлэгжамцын «Орчин цагийн дэлхийн байдлын тухай» орос хэлээр бичсэн номоос төвд хэлд шууд буулган бичсэн «Дэлхийн байдлын тухай» сонин ном зохиолууд иж бүрэн байна. Эдгээр номын зарим нь ганц хувь, гар бичмэл, баралмал ном байдаг. Эрт цагийн соёлын дурсгал болсон энэ их ном судрыг хайрлан хамгаалж карт каталог бичиж, данслан бүртгэхийн хамт ЗХУ-ын номын сан-ном зүйн ангилалын системд оруулж, орчин цагийн судалгаа шинжилгээнд бэлтгэх нөр их ажилд эхлэн орох гэж байна. Үүний хажуугаар гүн ухаан, түүх одон-зурхай, анагаах ухаан зэрэг эрдэм шинжилгээний зарим чухал ач холбогдолтой ном судрыг хувилж, уг эхийг хадгалах, үе үе номын эрэл хайгуул зохиох, ховор ном судрыг хуулан авч, эздийг нь урамшуулах, хүссэн номоор нь солилцоо хийх зэрэг олон төрлийн ажлыг өнгөрсөн 60 жилд зохион байгуулалттай явуулж ирсэн нь уг фондыг баяжуулахад чухал үр нөлөөг үзүүлж уг фонд одоо сая орчим номтой болжээ.

УННС-д үйлчлүүлэгчид болон гадаадын сонирхогчид жил ирэх тутам өсч жилд бараг 100 мянган хүн-уншигчдад хүрсний зэрэгцээ одоо 40 орчим улсын 80 гаруй номын сантай харилцан жилд 8 мянга орчим төрөл бүрийн ном солилцоогоор авч, хариуд нь өөрийн 3 мянга орчим ном хэвлэл илгээж байна. Тус номын санд ирж ховор нандин ном үзэн сэтгэл санаагаа гийгүүлсэн уншигчид, номын саигийн хамт олонд баяр талархлаа (санал хүсэлтийн улаан дэвтэрт) бичиж үлдээснийг олон мянгаар

тоолж болно. Энд нэг жишээг сонирхуулбал 1980 оны есдүгээр сарын 17-ны өдрийн нэгэн тэмдэглэлд Бутан гэдэг жижиг улсын хааны номын сангийн эрхлэгч эрдэмтэн лам Бадма, сургуулийн багш эрдэмтэн Надо нар «...монгол улсын энэ их номын санд Буддагийн их зарлиг Ганжуураас эхлээд эрт ба эдүгээгийн ертөнцөд маш ховорхон ном судрыг цэгцлэн тавьсан нь үзэж ханашгүй их баяр баясгалан төрүүлэв. Сэтгэлд тааламжтай энэ сайхан ховор нандин түүхийн дурсгалыг хойшид улам баяжуулан хамгаалж байх нь дамжиггүй» гэж төвд хэлээр бичжээ.

Ардын хувьсгалын дараа ганцхан тасагтай байгуулагдаж эдүгээ Ази тивд томоохонд тооцогдох болсон манай УННС-гийн энэ ууган фонд гадаад дотоодын эрдэмтэн мэргэд түүний дотор төвд, монголч зэрэг дорно дахины эрдэмтдийн анхаарлыг цаашид ч улам татах бөгөөд тус оронд Дорно дахины судлалын салбарыг хөгжүүлэхэд эрдэм шинжилгээний нэн чухал бааз болно.